



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/72

Номгон

Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын “б”, 29.1.6-ын “в”, 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, аймгийн Засаг даргын 2021 оны А/02, А/55 дугаар захирамж, аймгийн Онцгой комиссын 2021 оны 01 дүгээр албан даалгавар, аймгийн Онцгой комиссын 2020 оны 11 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хотод үүссэн коронавирусын тархалтын нөхцөл байдал, зарим аймгийн нөхцөл байдлын эрсдэлийг үнэлж, цар тахлын эрсдэл тус аймагт орж ирэхээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 06:00 цагаас аймгийн хэмжээнд зорчигч тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, хүн ам олноор төвлөрдөг аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг бууруулах болон цуцлагдах хугацаа хүртэл түр зогсоосугай.

2. Дээрх хугацаанд дараах арга хэмжээг чанар, үр дүнтэй зохион байгуулахыг зарим албан тушаалтанд үүрэг болгосугай.

2.1. Эрүүл мэндийн шалтгаанаар болон Онцгой комиссын хойшлуулшгүй ажлаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөн үйлдэх тохиолдолд аймаг дотроо сумдын Онцгой комиссын Шуурхай штабын зөвшөөрлийн бичгээр, аймаг болон хот хооронд явах тохиолдолд сумаас аймгийн Онцгой комисст хандаж, аймгийн Онцгой комиссын зөвшөөрлийн бичгээр замын хөдөлгөөнд оролцохыг,

2.2. Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хөдөлгөөнт болон хяналтын постыг нэмэгдүүлж, орон нутаг, иргэдийнхээ аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулж, гарах санхүүжилтийг сумын Засаг даргын нөөцөөс гарган гаднаас ирж байгаа иргэдэд тавих хяналт шалгалтыг эрчимжүүлэн ажиллахыг тус тус сумдын Засаг дарга нарт,

2.3. Тусгай үүргийн автобус, онгоцоор ирсэн иргэдийн тусгаарлах байрны болон гэрийн ажиглалтын үйл ажиллагааг хянах, холбогдох хяналт шалгалт, ажиглалтыг зохион байгуулж, дэглэм зөрчсөн иргэдийг хуулийн байгууллагад шилжүүлэн арга хэмжээ тооцож

1210179

2.4.Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа хяналтын постуудад ирсэн иргэд, ажиглалтад байгаа иргэд болон ажиглалтаас гарч байгаа иргэдэд хөдөлгөөнт лаборатори ажиллуулан сорил, шинжилгээ авч, халдвар хамгааллын дүрэм журмын дагуу арга хэмжээг зохион байгуулахыг аймгийн Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн (Н.Энхжаргал)-д,


2.5.Тусгаарлах байрыг нэмэлтээр байгуулж, шаардлагатай хүнс хангалтыг хийж, иргэдийг хүлээн авах ажлыг халдвар хамгааллын дүрэм, журам, зааврын дагуу зохион байгуулахыг Баянхонгор сумын Засаг дарга, аймгийн Онцгой комиссын гишүүн (Ж.Мөнхсоёл)-д,

2.6.Зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлаж, хяналтын постуудын үйл ажиллагааг холбогдох дүрэм, журмын дагуу зохион байгуулж, аймгийн хэмжээнд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлж, хяналт шалгалтыг эрчимжүүлэн зөрчил гаргасан иргэн, хуулийн этгээдэд хариуцлага тооцож ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн (цагдаагийн хурандаа Б.Оюутболд)-д,

2.7.Аймгийн Засаг даргын коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр гарсан захирамж, тушаал, албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах нэгдсэн арга хэмжээ (Иргэд ба халдвар хамгаалал)-г аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн (Н.Бямбадорж)-д,

2.8.Аймгийн Онцгой комиссын Шуурхай штабын үйл ажиллагааг эрчимжүүлэн, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, байгууллагуудын бэлэн байдлыг хангуулж, иргэдэд цар тахлын аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах сэрэмжлүүлэг мэдээллийг тогтмол цагт олон нийтийн хэрэгслээр хүргэж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын орлогч, Онцгой комиссын нарийн бичгийн дарга (дэд хурандаа Э.Батбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Дээрх арга хэмжээнүүдийг зохион байгуулалтын өндөр түвшинд хийж гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлж, энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН